

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 39.060

Мөнгөн аяга. Ерөнхий шаардлага

MNS 6505 : 2015

Silver cup. General requirements

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 13 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2015 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандартаар төрөл бүрийн тагшийг мөнгө (үнэт метал)-өөр бүрэх аргаар үйлдвэрлэсэн мөнгөн аяганы үйлдвэрлэх арга, шалгаж хүлээн авах, шошголоход тавигдах шаардлагыг тогтооно.

Энэ стандарт нь өргөн хэрэглээнд /бөөнөөр/ зориулж үйлдвэрлэх мөнгөн аяганд хамаарна.

Энэ стандарт нь мөнгөн аяганы ур хийцэд тавигдах шаардлагыг тогтоохгүй, цул болон хучилттай мөнгөн аяганд хамаарахгүй.

2 Норматив ишлэл

Энэ стандартад дараах иш татсан стандартыг хэрэглэнэ. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ. Үүнд:

1/ MNS 3477 : 1983 Мөнгө, мөнгөний хайлш. / Монгол улсын Засгийн газрын 2010 оны 281 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол улсын сорьцын хяналтын дүрэм"-ийн 2.1.в заалтад тусгагдсан сорьцтой/

3 Үйлдвэрлэх арга

3.1 Мөнгөн аягыг мөнгө, мөнгөний хайлшийг гар болон механик аргаар элдэж нимгэлэн төрөл бүрийн тагшийг бүрж үйлдвэрлэнэ.

4 Техникийн шаардлага

4.1 Бүрмэл мөнгөн аяганы дотрыг MNS 3477 стандартад заасан M 999.0 сорьцтой мөнгөөр, суурийг M3 925, 875, 835, 800 сорьцтой мөнгөний хайлшаар үйлдвэрлэнэ.

4.2 Өргөн хэрэглээнд зориулан үйлдвэрлэж байгаа бүрмэл мөнгөн аяганы тагшны хэмжээг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Тагшны хэмжээ

1-р хүснэгт

Тагшны төрөл	Хэмжээ			
	Амсарын голч /мм/	Өндөр /мм/	Жин /гр/	Эзэлхүүн /мл/
Тагш-1	75	28	34	50
Тагш-3	90	33	46	100
Тагш-4	105	38	105	180
Тагш-5	125	45	167	250
Тагш-5.5	135	50	204	350
Тагш-6	150	52	265	400
Тагш-7	160	56	334	550
Тагш-8	170	62	400	700
Тагш-12	185	70	408	1000

ТАЙЛБАР: Тагшны төрөлд бичсэн “Тагш 1, 2, 3 ... 12” эдгээр тоогоор Монголчууд нийтлэг хэрэглэдэг тагшны хэмжээг ялган хэлж хэвшсэн болно.

4.3 Өргөн хэрэглээгээр үйлдвэрлэх бүрмэл мөнгөн аяганд орох мөнгө, мөнгөний хайлшны орц, хэмжээнд тавигдах шаардлага нь 2-р хүснэгтэд заасны дагуу байна.

Мөнгөн аяганд тавигдах шаардлага

2-р хүснэгт

Мөнгөн аяганы төрөл	Мөнгө, мөнгөний хайлшийн хэмжээ				
	Амсарын мөнгөний зузаан /мм/	Суурийн мөнгөний зузаан /мм	Амсарын мөнгөний орц /гр/ 999-ийн сорьц	Суурийн мөнгөний орц /гр/ 925, 875, 835, 800 сорьц	Мөнгөний нийт орц /гр/
Мөнгөн аяга-1	0.15-аас багагүй	0.15-аас багагүй	10-аас багагүй	15-аас багагүй	25-аас багагүй
Мөнгөн аяга-3	0.20-иос багагүй	0.20-иос багагүй	15-аас багагүй	20-иос багагүй	35-аас багагүй
Мөнгөн аяга-4	0.20-иос багагүй	0.20-иос багагүй	22-оос багагүй	28-аас багагүй	50-иас багагүй
Мөнгөн аяга-5	0.20-иос багагүй	0.20-иос багагүй	32-оос багагүй	38-аас багагүй	70-аас багагүй
Мөнгөн аяга-5.5	0.20-иос багагүй	0.20-иос багагүй	42-оос багагүй	43-аас багагүй	85-аас багагүй
Мөнгөн аяга-6	0.22-оос багагүй	0.25-аас багагүй	50-иас багагүй	60-аас багагүй	110-аас багагүй
Мөнгөн аяга-7	0.22-оос багагүй	0.25-аас багагүй	68-аас багагүй	67-оос багагүй	135-аас багагүй
Мөнгөн аяга-8	0.25-аас багагүй	0.30-аас багагүй	84-өөс багагүй	71-ээс багагүй	155-аас багагүй
Мөнгөн аяга-12	0.25-аас багагүй	0.30-аас багагүй	118-аас багагүй	77-оос багагүй	195-аас багагүй

4.4 Мөнгөн аяганы дотор гадаргуу нь гөлгөр байна. Захиалагчийн хүсэлтээр үйлдвэрлэж байгаа мөнгөн аяганд энэ заалт хамаарахгүй.

4.5 Бүрмэл мөнгөн аяганы амсар, суурь нь цэвэр үзэмжтэй бөх бат хийгдсэн байна.

4.6 Мөнгөн аяганд үйлдвэрлэгчийн барааны болон сорьцын баталгааны тэмдгийг сайтар харагдахуйц газар, тод гаргацтай тавина.

5 Шалгаж хүлээн авах

5.1 Холбогдох эрх бүхий байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан мөнгөн аягыг худалдаанд нийлүүлнэ.

6 Шошго

6.1 Үйлдвэрлэгч нь мөнгөн аяга нэг бүрт дараах мэдээлэл бүхий шошго зүүнэ.
Үүнд:

- 1/ Үйлдвэрлэгчийн нэр, тэмдэг
- 2/ Сорьц
- 3/ Жин
- 4/ Худалдах үнэ

ТӨГСӨВ.